

К.Г.ЮНГИЙН ХУВИЙН НАМТАР НЬ АНАЛИТИК ПСИХОЛОГИ ОНОЛЫН ҮНДЭС БОЛОХ НЬ

Б.Цэрэнханд (Доктор Ph.D)
Ш.Отгонбатлагийн нэрэмжит Технологийн сургууль

Түлхүүр үг: Аналитик психологи. Эзотеризм. Психологийн атеизм. Архетив. Хамтын ухамсаргүй.

Товч агуулга: Швейцарын сэтгэл мэдрэлийн эмч, сэтгэл зүйч, соёл судлаач, нэртэй сэтгэгч, психоанализийн нэг чиглэл болох аналитик психологийг үндэслэгч Карл Густав Юнг (1875-1961) -ийн боловсруулсан аналитик психологи нь фройдизм, неофройдизмыг бодитойгоор ойлгож, тэдгээр дэх зарим философи үндэслэлийн дутагдлыг илрүүлэн, хүний сэтгэлийн онцлогийг үнэн зөв ойлгоход чухал алхам болсон гээж мэргэжлийн судлаачид үнэлдэг билээ. Бас К.Г.Юнгийн боловсруулсан философи баримтлал нь Өрнө, Дорнын психологийн философи ойлголтуудын нийтийг ба ялгааг харгалзсан чухал үр дүн байдал ажээ. Энэ бүгд нь орчин үеийн төвшиинд сэтгэл гээж юу болохыг авч үзээ гэвэл К.Г.Юнгийн философиid хандах ёстой гэсэн дүгнэлтэнд биднийг хүргэж байгаа юм. Харин К.Г.Юнгийн аналитик онолын эх сурвалж нь түүний хувийн амьдрал, намтраас нь үүдэлтэй гэж судлаачид дүгнэдэг. Энэхүү өгүүлэлдээ түүний онолын эх сурвалж болсон намтралын мэдээг онцлон авч үзэх болно.

К.Г.Юнг 1875 оны 7 сарын 6-нд энэ улсын Кессвил хотноо санваартны гэр бүлд дөрөв дэх хүүхэд нь болон төрсөн ч энэ айлын цорын ганц амьд үлдсэн хүүхэд нь аж. Түүний эцэг Карл Густав II Юнг бол ядуу санваартан байсан бол эх нь баян чинээлэг швейцари гэр бүлээс гаралтай еврей профессорын охин байв¹. К.Г.Юнгийн өвөө нь Гётегийн нууц хүү мөн гэсэн мэдээлэл ч байдал байна.²

К.Г.Юнгийн амьдралын туршлага нь түүний онолд чухал ул мөрөө үлдээсэн нь маргаан төрүүлэхгүй³ юм. Түүний онолыг намтраас нь салган судлаж болохгүй гэдгийг олон судлаачид анхааруулан бичсэн байдал. Жишээ нь:

¹ Bair, D. (2003). As a university student Jung changed the modernized spelling of his name to the original family form. In Jung: A Biography. (pp. 7-8). New York: Back Bay Books.

² Батболд, Ш. (2010). Сэтгэл судал, сонгодгүүд. Улаанбаатар, х. 246

³ Тухайлбал: Дуан П.Шульц, Сидни Элен Шульц. (1998). История современной психологии. Санкт-Петербург, с.440; Туяа, Б. (2003). Бие хүний сэтгэл зүй, сэтгэц заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид. Улаанбаатар, х. 104; Батболд, Ш. (2010). Сэтгэл судал, сонгодгүүд Улаанбаатар, х. 246.; As a university student Jung changed the modernized spelling of his name to the original family form Bair, Deirdre (2003); Jung: A Biography. New York: Back Bay Books. p. 7-8, 53 зэрэгт энэ тухай үзнэ үү.

Английн аналитик психологич Э.Самуэльс⁴: К.Г.Юнгийн онолыг түүний амьдрал, намтраас нь үндэслэн тайлбарлаж л онолыг судлах ёстой байдаг бөгөөд энэ ажлыг олон эрдэмтэд хийсэн гэж бичсэн байдал. Ийнхүү Юнг судалалын эрдэмтэд К.Г.Юнгийн хувийн намтарыг аналитик психологийн онолтой нь зэрэгцүүлэн судалгаа хийдэг бөгөөд энэ үйл явц Өрнөдөд идэвхитэй өрнөдөг юм.

Өөрөөр хэлбэл, К.Г.Юнгийн намтар бол жирийн нэг намтар бус, харин К.Г.Юнгийн онолын үндэс болсон туршлагууд болж өгсөн байдал ажээ. Ийм дүгнэлтийг зөвтгөсөн зарим зүйлийг түүний намтралын мэдээнээс дурдья.

К.Г.Юнгийн намтар судлалын гол эх сурвалж болсон бүтээл бол "Memories, dreams, reflections New York, (1963) (Дурдатгал, зүүд, эргэцүүлэл)." хэмээх өөрийнх нь бичсэн ном юм. Энэ ном бол зохиогч өөрийн хувийн амьдралынхаа туршлага, боловсруулсан философи онол хоёрынхoo холбоог ямар нэг хэмжээгээр харуулсан чухал сургамжтай зохиол билээ.

⁴ Samuels, A. (1985). Jung and the post – Jungians. London and New York. p. vi

Гэхдээ энэ номоо тэрээр амьд ахуй үедээ хэвлүүлээгүй бөгөөд түүний шавь нар түүнийг нас барснаас хойш 2 жилийн дараа хэвлүүлжээ.

К.Г.Юнг бага байхаасаа эхлэн зөн совингоороо далд, нууцлаг (өөрөөр хэлбэл манай ертөнцтэй зэрэгцээ оршдог ертөнцийн) зүйлсийг хардаг байсан аж. Энэ тухайгаа ”Дурдатгал, зүүд, эргэцүүлэл” хэмээх намтарчилсан бүтээлдээ: “түшмэлийн хар хувцас өмссөн хүн өрөөнд нь орж ирээд “Есүс Бурхан тэнгэр” гэж байн байн залбирч байгааг; биенээсээ салсан толгой их биенээсээ түрүүлэн хөвж яваа ер бусын үл ялиг гэрэлтсэн дүрс ээжийнх нь өрөөнөөс шөнө гарч явахыг харах”⁵ гэх мэт хачин жигтэй зүйлсийг бага байхаасаа харж эхэлсэн тухайгаа бичсэн байдаг. Ийнхүү хачин жигтэй зүйл хардаг байсан нь түүнийг эхэндээ айлгадаг байсан байна. Харин хожим нь ийм далдлаг учир шалтгаантай зүйлс К.Г.Юнгийг айлгахаа болж, харин ч түүнд хэрэг болж эхэлсэн тухайгаа өөрийн намтартаа бичжээ. Үүнд, түүний оккультив⁶ мэдлэг нь аналитик психологи онол боловсрогдоход ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Энэ тухай Э.Самуэльс “Jung and the post – Jungians (Юнг ба түүний дагалдагсад)” хэмээх номондоо бичихдээ: Юнг бол психологич, сэтгэл мэдрэлийн эмч мөн. Гэхдээ чухамдаа тэрээр гуру (guru)⁷ эсвэл зөнч мэргэн хүн (prophet) юм. Түүний энэхүү эзотерик чадвар нь Юнгийг аналитик психологи онолоо боловсруулахад хүргэжээ.⁸ К.Г.Юнгийн эзотерик мэдрэмж

⁵ Jung,C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York.p.18

⁶ Оккультизм (латин хэлний “нууц”, “далд” гэсэн утгатай угзээ гаралтай), эзотеризм (грекийн грек хэлний “доторхи”, “далд” гэсэн угзээс гаралтай үт) гэдэг хоёр нэр томъёог зарим зохиогчийн бүтээлд ижил утгаар, өөр зарим нь тодорхой ялгаа бүхий хэрэглэсэн байdag. Энэ диссертацид ямар утгаар хэрэглэсэнээ дурдья. Оккультизм бол тухайн нөхцөлжирүүний хүний хувьд үлгэр, шидэт домог, хоссон зохиомж, зөн совин юм шиг байдаг ч амьдралын явцад болон танин мэдэхүйн, тухайлбал шинжлэх ухааны хөгжлийн зохиц төвшинд улмаар зарим нь үнэн хэмээн нотлогдог тийм нууцлаг, далд зүйлс манай ертөнцд байдгийг зөвшөөрдөг үзэл мөн. Эзотеризм бол оккультизмыг өөртөө багтааж байдгийн зэрэгцээ манай ертөнцийн далдлаг зүйлс төдийгүй манай (физик) ертөнцтэй зэрэгцэж, бурэн бие дааж оршдог физик биш янз бүрийн ертөнч аваас бодгаль хүнд, хүмүүсийн хамглагт, улмаар нийт хүн төрөлхтөнд нөлөөлдөг нөхцөл байдлыг тайлбарладаг, товчоор хэлбэл манайхтай зэрэгцэн оршиж байсан ба одоо зэрэгцэн оршдог далд ертөнчүүд бий хэмээдэг гэгээнтүүдийн үзлүүлжээ.

⁷ Оюун санааны удирдагч

⁸ Samuels, A. (1985). *Jung and the post – Jungians*. London and New York.p. 20

нь түүний аналитик психологийн үндэс суурь болохыг судалсан судалгаа Өрнөнд их хийгдсэн байdag ажээ. Өөрөөр хэлбэл К.Г.Юнгийн эзотерик чадвар бол аналитик психологийн үндэс нь юм гэсэн санааг Э.Самуэльс чухалчлан онцолжээ.

Ийм оккультив чадвар нь З.Фройдын психоаналтикаас К.Г.Юнг цааш явж мистицизмийн арга зүйн үүднээс аналитик психологи онолоо боловсруулах үндэс, суурь нь болжээ гэж дүгнэж байна.

“Дурдатгал, зүүд, эргэцүүлэл” хэмээх зохиолдоо К.Г.Юнг аналитик психологи онол боловсрогдоход нөлөөлсөн өөрийн амьдралаа бичсэн байdag бөгөөд энд түүний амьдралын зөвхөн дөрвөн тохиолдлыг дурдья. Үүнд:

Нэг, К.Г.Юнг бичихдээ: “намайг б сартай байхад буюу 1875 онд эцэг, эх маань Кессвиллээс Лауфен дахь Констанцийн нуур луу нүүсэн юм. Энэ нь Рейне хүрхрээний дээхэн байрлах шиггүүрээн дэхь санваартны гэр байв. Рейне хүрхрээнд цохигдсон хүмүүс живэн, цогцоснууд нь хад чулуунд цохигдоно. Ер нь Рейне хүрхрээ надад маш их аймшиг төрүүлдэг байлаа. Ойрхон байрлах оршуулгын газарт авсчин нүх ухан шороог нь овоолж тавих бөгөөд ёслолын хувцастай номлогч байх ба бас сонин өндөр малгай, гялтганасан хар гутал өмссөн эрчүүд хар хайрцааг авчирцгаана. Тэнд санваартны хувцас өмссөн аав цангинасан хоолойгоор ярих ба мөн эмэгтэй хүн уйлах чимээ сонсогдоно. Энэ нүхэнд ямар нэгэн хүн булагдаж байгаа бөгөөд тэдгээр булагдсан хүмүүсийг Эзэн Есүс аваад явдаг гэж хэн нэгэн надад хэлж билээ. Энэ дурсамж маань Бурхан тэнгэрт эргэлзэх эргэлзээний эхлэлийг тавьсан юм⁹ хэмээн бичсэн байдаг. Ертөнцийг бүтээгч Бурхан тэнгэр ийнхүү үхлийн шалтгаан болж буй энэ байдал Юнгэд психологи зөрчлийг бий болгож психологийн атейст болох эхлэлийг энэхүү үйлдэл нөхцөлдүүлж өгчээ.

Цааш нь К.Г.Юнг бичихдээ “миний ээж удэш бүр хийж байх залбирал зааж өгсөн. Энэ нь надад тааламжтай байсан учраас тэрхүү залбиралд би их дуртай байсан юм. Яагаад гэвэл би шөнийн тодорхойгүй байдал мөн харанхуйгаас айдаг хүүхэд

⁹ Jung,C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York.p.22

байлаа. Харин энэхүү залбирал нь намайг тайтгаруулж тэрхүү айдсыг мартуулж байсан юм. Тэрхүү залбиралд:

“... Далавчaa дэлгэ дөлгөөн Эзэн Есүс минь

Тэгээд чиний дэгдээхэй болох биднийгээ ав ...¹⁰ гэх мэт мөрүүд байдаг.

Бяцхан хүүхдүүдийг тахиатай харьцуулж адилтгасан энэ байдал нь миний дургүйцлийг хүргэсэн бөгөөд энэхүү дургүйцэл маань Эзэн Есүсийг илэрхий тааламжгүйгээр хүлээн авах болгосон юм.

Эзэн Есүс олон олон сайн санаат шувуунуудаа алдаж, бүүдгэр хар ёслолын хувцастай, өндөр малгайтай, гялтганасан хар гуталтай, хар хайрцаг барьсан хүмүүстэй ихээр найзалдаг юм байна гэсэн миний бодол намайг маш ихээр шаналгадаг ба бас айлгадаг байв. Энэ үеэс эхэлж л би Бурхан тэнгэрт эргэлзэх болсон юм¹¹ хэмээн бичсэн байдаг. Энэхүү байдал нь түүнийг атеист, гэхдээ психологияйн атеист болгох сэтгэл зүйн нөхцлийг бүрдүүлжээ.

Хоёр, К.Г.Юнг бичихдээ: би зуны нэгэн халуун өдөр урьдын адил л гэрийнхээ урд талын элсэн дээр ганцаараа тоглож байв. Гэтэл урт хар гадуур хувцас өмссөн бас сонин малгайтай хүн модон дундаас ирж явааг харлаа. Энэ нь яг л эрэгтэй хүн эмэгтэй хүний хувцас өмссөн юм шиг харагдav. Тэр хүн наашаа ойртох тусам түүнийг хөлөө хүрсэн хар нөмрөг өмссөн эрэгтэй хүн болохыг олж харлаа. Түүнийг харсан даруйдаа миний бие айсаар дүүрч энэ Есүйт¹² (Jesuit) байна гэж гэнэт бодогдов. Энэ явдлаас өмнө манайд зочилж ирсэн аавтай хамт ажилладаг хүмүүс болон аавын яриаг би санаандгүй сонсчихож билээ. Тэд Есүйтийн өөдгүй үйл ажиллагаануудын талаар ярьж байсан юм. Аавынхаа бага зэрэг уурласан, бас айсан хоолойноос Есүйт гэдэг нь ямар нэг аюултай зүйл бөгөөд аавд ч хүртэл аюултай юм байна гэж би ойлгосон. Тэр Есүйт гэдэг нь миний залбирал дээр гардаг Есүс гэдэг үгтэй ойролцоо юм байна гэж тэр үед бодож билээ. Тэр хар хүнийг хараад айсандаа би санд мэнд гэрлүүгээ гүйн орж, шатаар

¹⁰ ibid. p.23

¹¹ ibid. p.24

¹² “Есүйт” гэж Гэгээн Игнашиус Лоёолагийн байгуулсан Есүсийн Нийгэмлэгийн Ромын Католик чуулганы зөвхөн эрэгтэй хүмүүстэй шашны гишүүн.

маш хурдан өгсөж, дээвэр дээрх хамгийн харанхуй буланд орж нуугдлаа. Дараа нь би тэр хар зураглалыг миний католик шашны гэм хоргүй төсөөлөөл гэдгийг ойлгосон юм¹³ хэмээн К.Г.Юнг бичсэн аж.

Гурав, К.Г.Юнг 3-4 насандaa өөрийг нь олон жил зовоосон нэгэн зүүд зүүдэлсэн байна. Энэ тухайгаа тэрээр бичихдээ: Миний амьдралын туршид санаа зовоосон нэг зүүд байдаг. Энэ зүүд бол миний санаж чадах хамгийн эртний зүүд юм. Би 3 юм уу 4 настай байсан байх. Би зүүдэндээ нэгэн хадлангийн газар харлаа. Гэнэт тэгш өнцөгт чулуугаар хүрээлүүлсэн харанхуй нүх газарт байхыг харав. Би өмнө нь хэзээ ч ийм зүйл харж байсангүй. Би сониучлан урагшаа гүйн очив. Дараа нь тэр нүх рүү орох чулуун шат байгааг олж харлаа. Би эргэлзэн айсаар тэр шатаар доош буухад ногоон хөшгөөр халхалсан дугуй хэлбэртэй хаалга байв. Тэрхүү хаалга маш нарийн чимэглэлтэй тансаг харагдаж байлаа. Хаалганы цаана юу нуугдаж байгааг мэдэхийг би хүсэв. Тиймээс тэрхүү хаалгыг түлхэн би дотогш орлоо. Бүдэгхэн гэрэлтэй 30-н фунтын урттай тэгш өнцөгт хэлбэртэй өрөө(зоорь) байв. Тэр өрөө дугуйлж зассан чулуун таазтай. Шал нь чулуун хавтангаар хийгдсэн байх ба орох хаалганаас голоо хүртэл улаан хивс дэвсээтэй байх аж. Тэнд алтаар хийгдсэн маш гайхалтай хаан ширээ байв. Яг л үлгэрт гардаг шиг. Хаан ширээн дээр 12-15 фунтын өндөртэй, 1.5-2 фунтын зузаантай мод байна гэж би анх харав. Тэр маш том бараг л таазанд хүрч байлаа. Гэвч тэр зүйл мод биш байсан юм. Энэ хачин зүйл нь арьсгүй махан биетэй, үсгүй дугуйрсан толгойтой ямар нэгэн сонин зүйл хөдөлгөөнгүйгээр толгойныхоо дээд хэсэгт байрлах ганц нүдээрээ намайнг цоо ширтэн зогсож байв. Ямар ч цонхгүй, өрөөнд гэрэл гарах ямарч боломжгүй байхад тэр үсгүй толгойноос гэрэл цацарч байлаа. Тэр хөдөлгөөнгүй зүйл хаан ширээнээсээ юу юугүй өт шиг мөлхөн буугаад над руу хүрээд ирэх юм шиг санагдаж байлаа. Би айdas, түгшүүрээр дүүрэн байв. Яг тэр мөчид “Чи зөвхөн түүнийг хар даа. Тэр бол аюултай махчин” гэж хэлж буй ээжийнхээ дууг сонсов. Энэ нь миний айдсыг улам бүр ихэсгэв. Би маш их хөлөрчихсөн, их

¹³ Jung C.G. (1963). Memories, Dreams, Reflections. New York.p.24

айдастай сэрэв.¹⁴ Энэ зүүд намайг олон жил зовоосон. Дахиж ийм зүүд зүүдлэхвийдээ гэхээс орой унтахаасаа ч хүртэл айдаг болсон байлаа. Би сүүлд нь зүүднийхээ учрыг олсон. Миний зүүдэндээ харсан тэр зүйл гэрэл болохыг ойлгосон юм. “Энэ бол махчин”, “Тэр бол махчин” гэж хэлсэн ээжийн хэлсэн үгний утгыг жаахан байхдаа огтхон ч ойлгоогүй бөгөөд ойлгох гэж их цаг зарцуулж билээ. Би “Энэ бол махчин” гэдгийг Эзэн Есүс, “Тэр бол махчин” гэдгийг гэрэл гэж тэмдэглэсэн. Тиймээс харанхуйн Эзэн Есүс болон тэр гэрэл хоёр адилхан юм. Хадлангийн газарт байсан нүх нь магадгүй булийг дүрсэлсэн байх магадлалтай юм. Булш нь өөрийн гэсэн газар доорх сүмтэй. Ногоон хөшиг нь хадланг(зүлэг, ногоог) өөрөөр хэлбэл байгаль дэлхийг дүрсэлсэн. Тэгвэл зоорь юу вэ? Магадгүй тэр бол аль эрт байсан Мунот дахь Шаффхаусений цайз байж болох юм. Гэхдээ энэ нь гуравхан настай хүүхдийн хувьд очиж үзэх боломжгүй юм. Тэгэхээр энэ зүүд гурван настай хүүхдийн дурсамжийн эргэн саналт биш гэдэг нь илэрхий.

Хожим нь шашны зан үйлийг судлаад би өөрийгөө хүүхэд шиг биш байсан гэдгээ ойлгосон. “Надтай ярьж, миний чихэнд ээжийн минь дүрээр түүний дуу хоолойгоор орж ирсэн хүн хэн бэ?”, “надад хэний оюун ухаан ирсэн бэ?” “тэр оюун ухаан(хүн) ясан их мэдлэгтэй юм бэ? гэсэн асуулт гарч ирсэн. Хэрвээ тэр нимгэн боловсролтой хэн нэгэн байсан бол хүний мах идэгч, гэрэл цацруулагч гэх мэт хуучны мэдлэгүүдээс надад ярьж өгч чадахгүй байсан¹⁵ юм хэмээн бичсэн байdag.

К.Г.Юнг энэхүү зүүдээ нэгтгэн дүгнээд зүүдэнд үзэгдэх гэрэл бол харанхуйн Бурхан тэнгэр юм¹⁶ хэмээн зүүдээ тайлбарлажээ.

К.Г.Юнг цааш нь бичихдээ: Эзэн Есүс хэзээ ч надад үнэн, бас хайрлагдсаар санагдаж байгаагүй. Би түүнийг хэзээ ч хүлээн зөвшөөрч байгаагүй юм.¹⁷ Чухамдаа бол миний хамгийн их сонсож, залбирдаг байсан Бурхан тэнгэрийн хайр энэрэл болон сайхан сэтгэл нь надад эргэлзээтэй санагдсан. Яагаад гэвэл Есүсийн талаар

¹⁴ Jung C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York p.24

¹⁵ Jung C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York p.30

¹⁶ ibid. p.26

¹⁷ ibid. p.27

ярилцдаг хүмүүс нь голдуу оршуулгыг санагдуулам хар өнгийн хүрэм болон гялтгар хар гутал өмссөн байх ба Есүсийг санагдуулам хүмүүс байдаг. Миний найман авга ах нар бүгд пастор байсан. Миний олон жилийн айдсын шалтгаан нь тэд байсан¹⁸ гэж К.Г.Юнг бичсэн юм.

Эндээс үзэхэд Эзэн Есүс эргэлзэх гол шалтгаан нь Есүс хамгийн ойр байдаг, Бурхан тэнгэрийг хамгийн ихээр хайрлаж, Түүнийг байнга ярьдаг байсан пасторууд болон тэдний зан үйл нь К.Г.Юнгийг маш ихээр айлгадаг байсанд оршиж байгаа юм. К.Г.Юнг Эзэн Есүсийг католик шашны пасторуудтай адилтган үзэж байсан нь дээрхээс илэрхий харагдаж байна.

Есүйтээс К.Г.Юнг маш их айдаг байсан бөгөөд энэ айдас нь түүний Есүйт ба Есүс хоёрыг адилтгаж, энэ адитгал нь Есүст эргэлзэх шалтгаан нь болж өгсөн бололтой юм.

Ийнхүү К.Г.Юнг дээрх зүүдний тайллыг 3 настай хүүхдийн ухамсраас хайсангүй. Харин дээд оюун ухаантай хэн нэгэн зүүдэнд нь орж ирсэн эсвэл түүхийн бүхий л үеийг агуулсан архетипийн илрэл гэж үзэж байгаа нь илэрхий байна.

Дөрөв, К.Г.Юнг 12 насандаа (1887 онд) сүмийн оройн цаанаас мандаж буй нарыг Бурхан тэнгэр (God)-тэй адилтган харж, ийм мэдрэмж нь дотоод бодол, сэтгэлд нь маш хүчтэй нөлөөлсөн гэнэ.¹⁹

К.Г.Юнг өөрөө дурдсан энэ баримтуудаас дараах 2 дүгнэлтийг хийж болмоор байна. Үүнд: нэгдүгээрт, хүүхэд насанд тохиолдсон эдгээр зүүд, дурсамжууд нь “хамтын ухамсаргүй”, түүний дотор “архетип” гэдэг үнэлэмжийн онолын үндэслэл гаргаж ирэхэд чухал тулхэц болжээ. Э.Самуэльс энэ тухай бичихдээ: “архетип” хэмээх ойлголт үүсэх үндсэн анхдагч шалтгаан нь Юнг өөрөө өөрийгөө шинжилсэнд оршдог”²⁰ гэжээ. Ингэж дүгнэх үндэслэгээ болох олон чухал психологи баримтыг К.Г.Юнг зохиолууддаа дурдаж ирсэн юм хэмээн Э.Самуэльс бичсэн байdag. Тиймээс К.Г.Юнгийн хувийн амьдрал, намтар нь түүний боловсруулсан

¹⁸ ibid. p.27

¹⁹ Jung C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York p.21

²⁰ Samuels, A. (1985). *Jung and the post – Jungians*. London and New York. p. 20

онолоос дутахааргүй чухал судалгааны объект болдог гэсэн дүгнэлтэнд бид хүрч байгаа болно.

Хоёрдугаарт, зохиогчийн дурдсан сүүлийн баримтаас: К.Г.Юнгэд сүмийн цаанаас мандаж буй нарнаас төрж буй сэтгэгдэл бол түүнд Бурхан тэнгэр болон сүмээс илүү бодитой бөгөөд агуу их сүр хүчтэй байсан ажээ. Тэр(1887оны) үед Бурхан тэнгэрийг далд Дээд бүтээгч биш гэж, харин байгалийн ээлтэй хүч гэж дүрслэн бодсон ийм(католик шашны эсрэг) сэтгэгдэл нь Библийн агуулгатай харш болох нь ойлгомжтой. Гэсэн хэдий ч К.Г.Юнг Англи, Ромын католик шашны санваартан нартай насан туршдаа найрсаг, нөхөрсөг харилцаатай байсан байна.

Ийм дүгнэлтээ зөвтгөсөн нэг баримт дурдья: 1959 онд BBC телевизийн “Нүүр тулсан ярилцлага” хэмээх нэвтрүүлэгт К.Г.Юнг дараах ярилцлагыг өгчээ.

-Хөтлөгч Жон Фримэн: та Бурхан тэнгэрт итгэдэг байсан уу ?

-К.Г.Юнг: тийм.

-Хөтлөгч: одоо та итгэдэг үү ?

-К.Г.Юнг: Одоо юу? (бодов) Хариулахад хэцүү л юм. Би учрыг нь мэддэг. Гэхдээ итгэх шаардлагагүй хэмээн хариулсан юм.

Энэ бүгдээс үзэхэд К.Г.Юнг атеист байжээ гэж бид үзэж байгаа болно. Өрнөдөд Бурхан тэнгэр (God)-ийг зарим философич байгальтай адилтгадаг (өөрөөр хэлбэл пантеист үзэл сурталчилдаг) бол К.Г.Юнг хамтын ухамсаргүйтэй, бүр тодруулж хэлбэл янз бурийн овог, хүн ам, үндэстэн, ард түмэн тус бурийн өвөрмөц хамтын ухамсаргүйн чухал элемент болох бэлгэдэлт архетипуудын цогцой адилтгажээ. Арга зүйн ийм байр сууриа буддын шашинд ч гэсэн тэрээр холбогдуулсан гэж үзэх үндэстэй.

К.Г.Юнгийг 6 настай байхад түүний эх нь сэтгэл гутралд (депресс) их автаж, унтлагын өрөөндөө өөрийгөө тусгаарлан олон цаг болдог байж. К.Г.Юнгэд ээж нь: “Над дээр шөнө болгон сүнснүүд айлчлан ирдэг”²¹ хэмээн хэлдэг байжээ. К.Г.Юнгэд зарим шөнө ээжийнх нь өрөөнөөс

аймшигтай зүйл мэдрэгддэг байсан аж. Шөнөдөө түүний ээж учир битүүлэг болж, танихын аргагүй өөр хүн шиг болдог байсан тухай К.Г.Юнг өгүүлдэг. Ээжийнх нь биеийн энэ байдал түүнийг анх удаа сэтгэцийн эмгэгтэй танилцуулжээ. Магадгүй ээжийнх нь сэтгэлийн ийм хувирал түүнд хожим архетипийг боловсруулахад нөлөөлсөн байх.

Ээжийнх нь өвчин К.Г.Юнгийг аавтайгаа илүү сайн харьцаатай байх нөхцлийг бий болгосон байна. Хожим тэрээр BBC телевизийн “Нүүр тулсан ярилцлага” хэмээх нэвтрүүлэгт энэ тухайгаа өгүүлсэн юм. Тухайлбал хөтлөгч: **та аав, ээж хоёрынхоо хэнтэй нь илүү дотно байсан бэ?** гэхэд **К.Г.Юнг:** “Хариулахад хэцүү асуулт байна. Мэдээж хүн бүр ээжтэйгээ илүү дотно байдаг, гэхдээ миний хувьд би аавтайгаа илүү ойр байснаа санаж байна. Ээжийг бодвол аав таахад хялбар хүн байсны зэрэгцээ маш нууцлаг мэт санагддаг байсан. Гэхдээ би ээжээсээ айдаг гэдгээ ойлгосон, ингэхдээ өдрийн цагаар биш. Өдрийн цагаар түүнийг би сайн мэддэг, таахад хялбар байдаг. Харин би ээжээсээ шөнө айдаг байсан”²² хэмээн ярилцлага өгжээ.

Психоаналитикт “либидо”, “эдипийн комплекс” гэх мэт чухал ойлголтууд байдаг. З.Фройдын боловсруулсан эдгээр ойлголтуудтай К.Г.Юнг санал нийлдгүй юм. Жишээ нь тэрээр эдипийн комплексийг үгүйсгэсэн байна. Учир нь, түүнд ийм туршилага хүүхэд насны хүсэлд нь огт байгаагүй аж. Энэ нь магадгүй түүний эх сэтгэл гутарлын эмгэгтэй байсантай ч холбоотой байж болох юм гэж бид таамаглаж байгаа билээ. Бидний үзэж байгаагаар, хэрвээ К.Г.Юнгийн ээж хэвийн, эрүүл хүн байсан бол тэрээр З.Фройдын эдипийн комплексийг хүлээн зөвшөөрөх байсан магадлалтай байгаа юм. Шөнийн цагаар ээжээсээ аих түүний айдас нь эдипийн комплексийг эсэргүүцэх гол үндэслэгээ болсон болов уу гэж бид үзэж байна. К.Г.Юнгийн хүүхэд насны дурсамж, ялангуяа 3-4 настайих нь дурсамжууд нь түүний амьдралынх нь туршид хадгалагдан үлдэж, улмаар ажил, амьдралынх нь үндэс

²¹ Jung C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York.p.18

²² Фримэн, Ж. (1959 оны 10 22). «Нүүр тулсан ярилцлага». “Нүүр тулсан ярилцлага”. (К.Г.Юнг, Ярилцагч) BBC телевиз. Их Британи.

суурь, зарчим байнга болсон ажээ.²³ Дээрх бүтдээс дүгнэлт хийвэл К.Г.Юнгийн хувийн амьдрал нь түүний онолд чухлаар нөлөөлжээ.

К.Г.Юнг хүүхэд байхдаа модон шугамаар очижүүхэн жижиг манекен хийж, үзэгнийхээ саванд байнга авч явдаг байжээ. Дараа нь тэрээр манекендаа чулуу нэмж, дээрээс нь доош хүргэл олон өнгөөр будаад дээврийн хөндийдөө нуусан байна. Үе үе тодорхой хугацааны дараа манекенээ эргэн очдог байж. Ингэж эргэж очихдоо тэрээр очижүүхэн жижиг цаасан дээр өөрийн мэдэх, өөрөөр хэлбэл өөрийн зохиосон нууц хэлээр юм бичээд очдог болжээ. Энэхүү зан үйлийг хийснээрээ тэрээр өөртөө сэтгэлийн дотоод амар амгаланг бий болгож, тайвширч, өөрийн дотоод өртөнцдөө нэвтрэн орж чаддаг байжээ.²⁴

Хүүхэд ахуйн ийм дурсамж ганц К.Г.Юнгэд бус, ер нь бага насын хүүхдүүдэд элбэг тохиолддогийг бид мэнднэ. Жишээ нь: монгол хүүхдүүд чулуугаар ийнхүү тоглох нь элбэг байдаг. Мөн тоглож буй тоглоомтойгоо ярилцаж, хүсэж буй дүрдээ тэрхүү тоглоомыг хувиргаж чаддаг. Ер нь монгол хүүхдүүдийн хувьд тайвшрал авчирдаг анхны тоглоом нь үнэгний дүрс бүхий эсгийн тоглоом байдаг гэж хэлж болно. Бэлгэдэлт утгаар тайлбарлавал дөнгөж төрсөн нялх хүүхдэд хүртэл психологийн хувьд тайвшрах хэрэгцээ бас байдаг байна гэж хэлж болохоор байна. Тоглоом бол өнгөц харахад зугаа цэнгэлийн эд мэт боловч үнэндээ психологийн хүмүүжилийн асар их үүрэг гүйцэтгэдэг бэлгэдэл юм.

Эндээс хэдэн хэдэн асуулт гарч ирж болохоор байдаг. Жишээ нь, ер нь яагаад хүүхдүүд тоглоомоор тоглодог вэ? Зарим хүүхдүүд эмч болж тоглодог байхад, зарим нь яагаад багш болж тоглох дуртай байдаг вэ? Яагаад охин хүүхдүүд машинаар, хөвгүүд хүүхэлдэйгээр тоглодогтүй вэ? гэх мэт асуудлууд гарч болох юм. Эдгээрийг К.Г.Юнгийн онолын үүднээс тайлбарлавал, эдгээр тоглох үйл явц бүгд бэлгэдэлүүд байх бөгөөд архетипүүдийг шингээсэн байдаг. Өөрөөр хэлбэл өөрт буй хүн

төрөлхтний нийтлэг мэдлэгийг хүүхдүүд тоглох явцдаа сэргээдэг байж магадгүй юм гэсэн таамаглал дэвшиүүлж байгаа болно. Иймд тоглоом хүүхдийг хөгжүүлэгч нэг гол хэрэгсэл байdag. К.Г.Юнгийн онолын үүднээс тайлбарлавал тоглоом хүүхдийг хөгжүүлж буй биш харин сэргээн санах үйл явцад туслагч юм гэж хэлж болохоор байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн ухамсаргүйг илэрхийлэх нэг гол хүчин зүйл нь тоглоом юм гэсэн дүгнэлтэнд хүрч байгаа болно.

К.Г.Юнг өөрийн хийсэн манекентэйгээ тийнхүү харьцаж байсан нь Австралийн Арлешийн ойролцоо нутгийн уугуул иргэдийн чулуу шүтэх тотемтэй адил байгааг хожим мэдсэн аж. Энэхүү үйлдэл нь юу ч мэдэхгүй жаахан хүүхдийн хувьд уг үйлдлийг ухамсартайгаар (өөрөөр хэлбэл үйлдлийнхээ утга учрыг мэдээд) хийх ямар ч боломжгүй, жаахан хүүхдээс гарамгүй алсыг харсан үйлдэл байсан юм гэж К.Г.Юнг бичжээ. “Хамтын ухамсаргүйгээрээ энэ үйлдлийг хийж байсан юм байна гэдгээ хожим би ухамсарласан”²⁵ гэж тэрээр бичсэн байдаг. Тодруулж хэлбэл К.Г.Юнгэд төрж байсан ухамсаргүй нь аль эрт Австралийн зарим нутгийн уугуул иргэдэд байсан аж. Ийм дурсамж нь хүнд “хамтын ухамсаргүй” байдаг юм байна гэсэн таамаглал дэвшиүүлэхэд түүнийг хүргэсэн бөгөөд түүгээр ч барагчийн аналитик психологи сургаалынх нь арга зүй болсон үйл явдал байв.

К.Г.Юнг багадаа гурван удаа ухаан алдаж, муужран унасан аж. Эцэст нь тэрээр үүнийгээ даван туулж чадаад, дахин ухаан алдаж унаагүй байна. К.Г.Юнг хожим нь энэ үйл явдлаа эргэн санаж ”Би тэр үед л невроз гэж юу болохыг мэдсэн”²⁶ гэж бичиж байлаа. Ийнхүү неврозыг өөрийн биеэр мэдэрсэн түүний туршилага нь сэтгэцийн өвчнийг эмчлэх, тайлбарлах талбарт амжилт олсных нь үндэс байж болох юм.

З.Фройдын бүтээлтэй танилцсанаар К.Г.Юнгэд шинжлэх ухааны үзэл төлөвшихэд их түлхэц болсон аж. Ялангуяа З.Фройдын “Зүүд нойрыг тайлбарлахуй, (1900)” бүтээлийг ихэд сонирхож, психоаналитик онолыг практикт хэрэглэж эхэлсэн. Гэвч тэд ойрхон нөхөрлөж байсан

²³ Jung.C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York.p.17

²⁴ Jung.C.G. (2006). *The Art Therapy Sourcebook*. McGraw-Hill Professional. Malchiodi, Cathy A. p.134

²⁵ Jung.C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York.pp.

22-23

²⁶ ibid. p.32

ч өөрсдийн үзэл бодлоор ялгаатай байлаа. Тэдний хооронд үзэл бодлын зөрчилдөөн үүссэн гол шалтгаан нь “либидо”, “ухамсаргүй”, “секс”-ийн асуудал байлаа. Улмаар 1913 онд тэр хоёрын харищаа тасарсан аж. Учир нь 1912 оноос эхлэн “архетип” хэмээх ойлголтыг психоанализд хэрэглэх болсон юм. Мөн онд К.Г.Юнг “Wandlungen und Symbole der Libido(Хувьсал ба либидогийн бэлгэдэл)” гэдэг ном хэвлүүлсэн бөгөөд энэхүү номондоо: “либидо” гэдэг бол амьдралын эрчмийг илэрхийлж байгаа сэтгэлийн энерги мөн. Тэр нь хүний хөгжлийн үе болгон дээр өөр өөр хэлбэрээр илэрдэг. Харин секс бол дээрхийн зөвхөн нэг хэлбэр юм гэж К.Г.Юнг үзэж байв.

Зарим аймшигт зөн нь К.Г.Юнгийг зовоодог байж. Тэрээр: “би хойд зүгээс эхлээд Альпын нуруу хүртэл дэлхий бүхэлдээ цусаар хучигдаж байгааг харж байна. Далай тэнгисийн ус хүний цусаар будагдаж, тоо томшгүй хүний цогцос дүүрэн байхыг харж байна”²⁷ гэж байв. Энэ бол 1913 оны 10-р сар байсан. Жилийн дараа дэлхийн 1-р дайн дэгдсэн юм. Ингэж янз бүрийн юм харж, мэдрэх болсон нь тэрээр хамтын ухамсаргүйн талаарх онолоо боловсруулах сэдэлт болжээ. К.Г.Юнг дэлхий 1-р дайныг мэдрээд ч зогсоогүй бөгөөд тэрээр дэлхийн 1-р дайны үед цэрэгт татагдаж армид орсон. Удалгүй Английн цэрэгт баригдаж Английн цэргийн лагерьт хоригдож байсан түүх бас түүнд бий.

Тэрээр гол нь психологийн шинжлэх ухаан, практикийн салбарын судлаач хүн байсан хэдий ч мэдлэгийн бусад салбарт, тухайлбал өрнө, дорнын философи, социологи, зурхай, мөн түүнчлэн урлаг, уран зохиол судлахад ажил амьдралаа зарцуулсан хүн юм. Бид энд философи судалгааг онцолж буй нь ойлгомжтой.

К.Г.Юнг өөрийнхөө амьдралыг дүгнэн бичихдээ: “миний амьдрал бол ухамсаргүйг өөрөө ухамсарласан түүх юм”²⁸ хэмээсэн байдаг. Ийнхүү түүний судалгааны гол зорилго нь хүн төрөлхтний сэтгэлийн нэн гүнд нь байгаа чадвар, чадавхийг нээх явдал байв. Тэрээр энэ зорилгынхoo хүрээнд

багагүй амжилт олсон судлаач билээ. Жишээ нь: хамтын ухамсаргүйн ач холбогдлыг илэрхийлсэн судалгаа шинжилгээ хийсэн анхны хүн бол энэ сэтгэгч мөн.

69 насандaa буюу 1944 онд К.Г.Юнг зүрхний шигдээс өвчинеэр өвчлөн эмнэлэгт байхдаа өөрийнхөө өнгөрсөн амьдралыг ер бусын үзэгдлээр төсөөлөн харжээ. Тухайлбал, өөрөө газраас өндөрт нисч яваа юм шиг, хад чулуун дээгүүр дүүлж яваа ч юм шиг, урд нь Энэтхэг, зүүн талд нь Арабын цөл, гэтэл бас урд нь томхон цайз бий болж, түүний дотор ортол бүх л өнгөрсөн амьдрал нь ард хоцорсон мэтээр урьд өмнө нь тэр болгон мэдэрч байгаагүй зүйлээ мэдэрсэн гэнэ. Энэ агшинд түүнийг эмчлэгч эмч нь ертөнцийг энэ мөчид орхиж болохгүй гэж хэлснээр уг ер бусын үзэгдэл төгссөн байна. Хэдэн долоо хоногийн турш К.Г.Юнг эмчилгээгээ үргэлжлүүлэн хийлгэж байгаад эдгэрчээ. Эдгэрэн эмнэлгээс гарсны дараа түүний хувьд агуу их бүтээл туурвилын их үе эхэлсэн байна. Өвчтэй байх үеийн ер бусын үзэгдэл нь урам зориг, сэтгэлийн тэнхээ түүнд өгч, оккультив мэдлэгийг шамдан судлах болсон байна.

НОМ ЗҮЙ

1. Батболд.Ш. (2010). Сэтгэл судлалын сонгодогууд. Улаанбаатар: МУИС.
2. Bair, D. (2003). As a university student Jung changed the modernized spelling of his name to the original family form. In Jung: A Biography. (pp. 7-8). New York: Back Bay Books.
3. Jung.C.G. (1963). Memories, Dreams, Reflections. New York.
4. Jung.C.G. (2006). The Art Therapy Sourcebook. McGraw-Hill Professional. Malchiodi, Cathy A.
5. Samuels, A. (1985). Jung and the post – Jungians. London and New York.
6. Фишбейн.Н.В. (2002). Философско-культурологические и религиоведческие концепты теории К. Г. Юнга. Диссертация. канд.филос.наук: 09.00.13. Белгород.
7. Фримэн, Ж. (1959 оны 10 22). «Нүүр тулсан ярилцлага». “Нүүр тулсан ярилцлага”. (К.Г.Юнг, Ярилцагч) BBC

²⁷ Батболд, Ш. (2010). Сэтгэл судлал, сонгодгууд. Улаанбаатар, х. 247

²⁸ Jung.C.G. (1963). *Memories, Dreams, Reflections*. New York.p. 17

телевиз. Их Британи.

8. Юнг.К.Г. (1994). Аналитическая психология. (В.В.Зеленского, Перев.) Санкт-Петербург.

ABSTRACT

The article expresses the following conclusion, new aspects and arguments. In it:

- He mentioned that his private life had a great influence to develop psychoanalytic theory, and I emphasized making examples some of the argument documents by C.G.Jung.

- Even though C.G.Jung came out psychological philosophy field by adhering S.Freud's theory, but on furthermore of his researching, certain philosophical concepts, having different content and methodology had been processed. In it, priority, it can be mentioned the concepts of "collective unconsciousness" and "archetype".

- Whereas S.Freud concerned the unconsciousness with the individual, C.G.Jung viewed that unconsciousness could be explained relating to the just outside of the real consciousness and also shallow characteristic so that he said that because it is beyond the mankind mind and could be explained by esoteric range, it is expressed by the category of "collective unconsciousness".